

ТОВЧ ТАНИЛЦУУЛГА

"Хулгайлагдсан, эсхүл хууль бусаар экспортлогдсон соёлын эд зүйлсийн тухай" ЮНИДРУА-ийн конвенцын тухай

ЮНЕСКО 1980-аад оноос хулгайлагдсан, хууль бусаар экспортлогдсон соёлын эд зүйлийг хууль ёсны өмчлөгчид буцаах, эргүүлэн өгөх үйл ажиллагааг илүү хөнгөвчлөн боловсронгуй болгох, ойлгомжгүй үлдсэн асуудлыг тодорхой болгох, хувийн эрх зүйн хүрээнд зохицуулах боломжийг эрэлхийлж, олон чиглэлээр судалгааны ажлыг эхлүүлж "Хулгайлагдсан, эсхүл хууль бусаар экспортлогдсон соёлын эд зүйлсийн тухай" ЮНИДРУА (Хувийн эрх зүйг нэгтгэх олон улсын хүрээлэн)-ийн конвенцын төслийг боловсруулж, оролцогч талуудаар хэлэлцүүлэн, 1995 оны 6 дугаар сарын 24-ний өдөр Бүгд Найрамдах Итали Улсын Ром хотноо баталсан.

Конвенц нь удиртгал, V бүлэг 21 зүйл (I. Хэрэглэх хүрээ ба тодорхойлолт /1-2 зүйл/, II. Хулгайлагдсан соёлын эд зүйлийг эгүүлэн олгох /3-4 зүйл/, III. Хууль бусаар экспортлогдсон соёлын эд зүйлийг буцаах /5-7 зүйл/, IV. Ерөнхий заалт /8-10 зүйл/, V. Төгсгөлийн заалт /11-21 зүйл/-ээс бүрддэг.

Үндэсний хууль тогтоомжийн хүрээнд хулгайлагдсан, хууль бусаар экспортлогдсон соёлын эд зүйлийг асуудлыг Соёлын тухай хууль, Соёлын өвийг хамгаалах тухай хууль, Шүүхийн тухай хууль, Эрдэнэсийн сангийн тухай хууль, Эрүүгийн хууль, Зөвшөөрлийн тухай хууль зэрэг 24 эрх зүйн акт, дүрэм, журмаар зохицуулж ирсэн.

Салбарын яамнаас "Хулгайлагдсан, эсхүл хууль бусаар экспортлогдсон соёлын эд зүйлсийн тухай" ЮНИДРУА-ийн конвенцыг соёрхон батлах тухай хуулийн төслийн судалгааг 2018 оноос хийж эхлэн, албан ёсны оруулгыг гаргасан. Конвенцын хэрэгцээ, шаардлагыг урьдчилан тандан судалсан судалгааны тайланг 2022 онд, ЮНИДРУА-гийн конвенцыг соёрхон батлах тухай үзэл баримтлал, хуулийн төслийн үр нөлөөг үнэлэх судалгааны тайлан, хуулийн төсөлд хийсэн зардлын тооцооны тайланг хийсэн. Монгол Улсын Засгийн газрын 2024 оны 04 дүгээр сарын 17-ны өдрийн хуралдаанаар хэлэлцэж, дэмжигдсэн.

"Хулгайлагдсан, эсхүл хууль бусаар экспортлогдсон соёлын эд зүйлсийн тухай ЮНИДРУА-гийн конвенцыг соёрхон батлах тухай хууль"-ийн төслийг 2003 оноос хойш холбогдох салбарын төлөөлөл, олон нийтээр хэлэлцүүлж ЮНИДРУА-гийн итгэмжит төлөөлөгч, Монгол Улсын ГХЯ, БСШУЯ, ХЗЯ болон хууль хяналтын байгууллагын төлөөлөгч, соёлын салбарын эрдэмтэн, судлаачдыг оролцуулан 5 удаагийн сургалт хэлэлцүүлэг хийж 237 төлөөлөл оролцсон.

"Хулгайлагдсан, эсхүл хууль бусаар экспортлогдсон соёлын эд зүйлсийн тухай ЮНИДРУА-гийн конвенци"-д өнөөдрийн байдлаар уг конвенцод дэлхийн 63 улс гарын үсэг зурж, зөвшөөрсөн ба үүний дотор манай хөрш БНХАУ 1997 оны 05 сарын 07-нд нэгдэн орсон. ОХУ 1996 оны 06 сарын 29-нд гарын үсэг зурсан боловч соёрхон батлаагүй байна.

ТАНИЛЦУУЛГА

"Хулгайллагдсан, эсхүл хууль бусаар
экспортлогдсон соёлын эд зүйлсийн
тухай" ЮНИДРУА-ийн конвенцын тухай

ЮНЕСКО-ийн 1970 оны "Соёлын үнэт зүйлийг хууль бусаар хилээр гаргах оруулах, түүнчлэн өмчлөх эрхийг шилжүүлэхийг хориглох, урьдчилан сэргийлэх арга хэмжээний тухай" конвенц нь соёлын үнэт зүйлийн эсрэг гэмт хэрэг зөрчилтэй тэмцэх олон улсын хамтын ажиллагааны шинэ механизмыг бүрдүүлсэн ч зарим зохицуулалт хэтэрхий өрөнхий, эсхүл шаардлагатай зохицуулалт дутуу орхигдсоноос конвенцын зорилгын хүрээнд хэрэглэхэд оролцогч талуудын өмнө багагүй бэрхшээлийг учруулж байв. ЮНЕСКО 1980-аад оноос хулгайллагдсан, хууль бусаар экспортлогдсон соёлын эд зүйлийг хууль ёсны өмчлөгчид буцаах, эргүүлэн өгөх үйл ажиллагааг илүү хөнгөвчлөн боловсронгуй болгох, ойлгомжгүй үлдсэн асуудлыг тодорхой болгох, хувийн эрх зүйн хүрээнд зохицуулах боломжийг эрэлхийлж, олон чиглэлээр судалгааны ажлыг эхлүүлсэн байна. Энэхүү 10 гаруй жилийн судалгааны үр дунд "Хулгайллагдсан, эсхүл хууль бусаар экспортлогдсон соёлын эд зүйлсийн тухай" ЮНИДРУА (Хувийн эрх зүйг нэгтгэх олон улсын хүрээлэн)-ийн конвенцын төслийг боловсруулж, оролцогч талуудаар хэлэлцүүлэн, 1995 оны 6 дугаар сарын 24-ний өдөр Бүгд Найрамдах Итали Улсын Ром хотноо баталсан.

"Хулгайллагдсан, эсхүл хууль бусаар экспортлогдсон соёлын эд зүйлсийн тухай" конвенц нь 5 бүлэг, 21 зүйл, хавсралтаас бүрддэг. Өнөөдрийн байдлаар уг конвенцод дэлхийн 63 улс гарын үсэг зурж, зөвшөөрсөн байна, үүнээс эрх бүхий байгууллагын шийдвэрийн дагуу 41 улс нэгдэн орсон, 13 улс соёрхон баталсан бол Франц, ОХУ, Гурж, Сенегал зэрэг 9 улс гарын үсэг зурсан ч нэгдэн орох, соёрхон батлах талаар ямар нэг шийдвэр гаргаагүй байна /БНХАУ 1997 оны 07 дугаар сарын 05-ны өдөр нэгдэн орсон/.

"Хулгайллагдсан, эсхүл хууль бусаар экспортлогдсон соёлын эд зүйлсийн тухай" конвенц нь ЮНЕСКО-ийн 1970 оны "Соёлын үнэт зүйлийг хууль бусаар хилээр гаргах оруулах, түүнчлэн өмчлөх эрхийг шилжүүлэхийг хориглох, урьдчилан сэргийлэх арга хэмжээний тухай" конвенцууд нь өөр хоорондоо харилцан уялдаатай, нэг нэгнээ дэмжиж, нөхөн зорилготой олон улсын эрх зүйн баримт бичиг юм. Хэдийгээр 1995 оны конвенцод соёлын эд зүйл (cultural objects), 1970 оны конвенцод соёлын өмч (cultural property) /манай улс соёрхон батлахдаа "соёлын үнэт зүйл" гэж орчуулсан/ хэмжээн харилцан адилгүй нэр томьёо хэрэглэсэн ч конвенцын зорилгод хамаарах зүйлс 11 хэсэгт ижил утга агуулгаар тодорхойлон, хэрэглэж байна.

1995 оны конвенцод хулгайллагдсан, хууль бусаар хилээр нэвтрүүлсэн эд зүйлийг нэхэмжлэх хугацаа, уuguул оршин суугчдын соёлын эд зүйлийг өмчлөх эрх, нөхөн төлбөрийн нөхцөл, конвенцын зорилгыг хэрэглэхгүй байх нөхцөл,

өмчлөх эрхийг тогтоох үйл ажиллагаа зэрэг 1970 оны конвенцод заагаагүй зарим асуудлыг нарийвчлан зохицуулсан. Энэ нь оролцогч талуудыг соёлын эд зүйлийн хууль бус эргэлтээс сэргийлэх, тэмцэх, хор уршгийг арилгахад зохих хувь нэмэр оруулж байна. Жишээлбэл, 2013 онд АНУ-ыг хууль сахиулах байгууллагаас Монгол Улсын хилээр хууль бусаар нэвтрүүлж, худалдсан Т-батаарын олдворыг эргүүлэн өгөх үйл ажиллагааг 1995 оны конвенцод үндэслэн зохион байгуулсныг дурдаж болно.

Монгол Улсын хувьд гадаадаас соёлын эд зүйлсийг импортлох хэрэгцээ шаардлага бага хэдий ч өөрийн түүх соёл, өв уламжлал, ёс заншилд холбогдох эд зүйлсийг хууль бусаар хилээр гаргахаас урьдчилан сэргийлэх эрх зүйн орчныг боловсронгуй болгож, үндэсний чадавхыг бэхжүүлэх хэрэгцээ шаардлага өндөр байна. Учир нь сүүлийн жилүүдэд тодорхой сэдвийн хүрээнд хөдөө орон нутгийн ард иргэдийн гар дээрээс эд зүйлсийг худалдан авах, эсхүл хулгайлах замаар цуглуулж, зөвшөөрөлгүй хилээр нэвтрүүлэх зөрчил буурахгүй байгааг хууль сахиулах байгууллагаас анхааруулж байна. Түүнчлэн, соёлын эд зүйлийн хууль бус эргэлттэй үр ашигтай тэмцэхийн тулд улс орнуудтай хамтын ажиллагаагаа өргөжүүлэх, олон улсын эрх зүйн механизмыг ашиглах талаар ЮНЕСКО, ИНТЕРПОЛ, ЮНИДРУА (Хувийн эрх зүйг нэгтгэх олон улсын хүрээлэн) зэрэг олон улсын байгууллага зөвлөсөөр ирсэн.

Соёлын яамнаас дээрх бодит хэрэгцээ шаардлагад үндэслэн "Хулгайлагдсан, эсхүл хууль бусаар экспортлогдсон соёлын эд зүйлсийн тухай" ЮНИДРУА-ийн конвенцод нэгдэн орох нь зүйтэй гэж үзэн, Хууль тогтоомжийн тухай хуульд заасны дагуу хуулийн төслийг боловсрууллаа.

---оо---